

Улсын төсвөөс хайгуулын ажилд гарсан
зардлыг нөхөн төлөх тухай
ГЭРЭЭ

№ХАЗ-2015/12/39

Ерөнхий зүйл

Нэг талаас Ашигт малтмалын газар, нөгөө талаас ашигт малтмалын ордын 9192А тоот тусгай зөвшөөрөл эзэмшигч “Күнлүн” ХХК буюу Улаанбаатар хотын Чингэлтэй дүүргийн татварын албанд бүртгэлтэй аж ахуйн нэгжийн 9019006127 тоот гэрчилгээ бүхий /цаашид аж ахуйн нэгж гэх/ нь Ашигт малтмалын тухай хууль, Засгийн газрын 2007 оны 3 дугаар сарын 28-ны өдрийн дугаар 81 тоот тогтоолоор батлагдсан журмыг үндэслэн Улсын төсвийн хөрөнгөөр Улаанбаатар хотын Налайх дүүргийн нутаг дахь Налайх гол-1 шаврын ордын геологийн зураглалын ажлын зардлыг Улсын төсөвт эргүүлэн нөхөн төлөх нөхцөл, үе шат, төлбөрийн хэмжээ, хүлээх хариуцлагыг харилцан тохиролцож энэхүү гэрээг байгуулав.

Нэгдүгээр зүйл. Геологийн зураглалын зардлын нийт хэмжээ

Улсын төсвийн хөрөнгөөр Улаанбаатар хотын Налайх дүүргийн нутаг дахь Налайх гол-1 шаврын ордод байрлах 9192А тусгай зөвшөөрлийн талбайд Улсын төсвөөс нийтдээ (176.31) төгрөгийн зардлыг үндэслэн Засгийн газрын 2007 оны 81 дүгээр тогтоолоор батласан журамд заасан аргачлалын дагуу тооцоход 2015 оны 08 дугаар сарын 07-ны байдлаар **53,19** (тавин гурав доллар арван ёсөн цент)-н ам.доллар болж байгааг хоёр тал хүлээн зөвшөөрөв.

Хоёрдугаар зүйл. Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн хүлээх эрх, үүрэг

1. Энэхүү гэрээний нэгдүгээр зүйлд заасан зардлыг 1 жилийн хугацаанд төлөх бөгөөд төлбөр хийх өдрийн төгрөг, америк долларын ханшаар тооцож төгрөгөөр эсвэл шууд америк доллараар төлнө.

2015 онд 53.19 ам.долл. / тавин гурав доллар арван ёсөн цент /
(тоогоор) (үсгээр)

2. Энэхүү гэрээний Хоёрдугаар зүйлийн 2.1-т дурьдсан онд хийхээр хуваарилсан төлбөрийг тухайн онд 3-р улиралд Хавсралт 1-д заасан байдлаар Төрийн сан банкны төгрөгийн 900000712 Ашигт Малтмалын Газрын дансанд хийнэ.

3. Хайгуулын ажлын зардлын нөхөн төлбөр хийсний дараа уг төлбөр Ашигт Малтмалын Газрын дансанд орсон эсэхийг шалгаж болно.

4. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь энэхүү гэрээний 2 дугаар зүйлийн 2, 3-аар тохиролцсон үүргийн дагуу тухайн улирлын төлбөрөө улиралдаа багтаан хийгээгүй бол Ашигт малтмалын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 7 дахь заалтын дагуу хугацаа хэтэрсэн хоног тутам тухайн улиралд төлбөл зохих төлбөрийн 0.1 хувьтай тэнцэх торгууль төлнө.

Гуравдугаар зүйл. Ашигт малтмал, газрын тосны хэрэг эрхлэх газрын хүлээх үүрэг, эрх

1. Энэхүү Гэрээний нэгд заасан нөхөн төлбөрийн хэмжээг нөхөн төлбөр хийхээр тохиролцсон хугацаанд өөрийн санаачилгаараа өөрчлөхгүй.
2. Нөхөн төлбөр хийсэн хугацааг банкинд гүйлгээ хийсэн өдрөөр тооцно.
3. Нөхөн төлбөр хийсэн баримт бичигтэй танилцан төлбөрийн хэмжээ үнэн зөв эсэхийг магадлахдаа төлбөр хийсэн өдрийн америк доллар ба төгрөгийн Монгол Банкаас зарласан албан ёсны ханшийг баримтлана.


Дөрөв. Бусад зүйл

1. Ашигт Малтмалын Газар болон аж ахуйн нэгжийн төлөөлөгчид энэхүү гэрээнд гарын үсэг зурснаар гэрээ хүчин төгөлдөр болно.
2. Энэхүү гэрээний Хоёрдугаар зүйлийн 2 дахь заалтын биелэлтийг Ашигт Малтмалын Газар болон аж ахуйн нэгжийн төлөөлөгчид хамтран дүгнэж акт үйлдэнэ.
3. Гэрээг гурав хувь үйлдсэн бөгөөд нэг хувийг Улсын мэргэжлийн хяналтын газар, нэг хувийг Ашигт малтмалын газар, нэг хувийг ашигт малтмалын ордын тусгай зөвшөөрөл эзэмшигч тус тус хадгална. Гэрээний хувиуд нэгэн адил хүчин төгөлдөр байна. Гэрээ нь хавсралттайгаа нийт гурван хуудаснаас бүрдэнэ.
4. Аж ахуйн нэгж нь энэхүү гэрээний заалтуудыг биелүүлээгүй тохиолдолд Ашигт Малтмалын Газар нь шүүхэд хандаж болох бөгөөд шүүх ажиллагаатай холбогдон гарах зардлыг аж ахуйн нэгж хариуцан төлнө.

Гэрээ байгуулсан:

**АШИГТ МАЛТМАЛЫН ГАЗРЫГ
ТӨЛӨӨЛЖ:**

Уул уурхайн хэлтсийн
дарга...../С.Баттулга/



**ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ
ЭЗЭМШИГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

"Күндүн" ХХК-ий захирал
Лиу Жин Шан /



Улаанбаатар хот
2015 оны 08 дугаар сарын 18-ны өдөр

Ашигт Малтмалын Газар, "Күнлүн" ХХК-ийн Налайх-1 нэртэй тоосгоны шаврын ордон Хайгуулын ажлын зардлыг нөхөн төлөх гэрээ

Хавсралт №1

2015 онд

Улирлууд	Төлбөл зохих US\$	Төлбөр хийсэн өдрийн төгрөг ба америк долларын ханш	Төлсөн нь	Төлбөр хийсэн он сар өдөр бусад тэмдэглэл
1				
2				
3	53.19			
4				


3